




ISSUE #19

27 January 2012



ОУДС-ийн Мөсөн Гулгуурын талбайг ашиглах талаар



Эрхэм Хүндэт Багш, Сурагчид, Эцэг Эхчүүд ээ

ОУДС энэ жил дахин мөсөн гулгуурын талбай байгууллаа. Бидний байгуулсан мөсөн талбай дээр та бүхэн өвлийн улирлын үлдсэн хугацаанд тэшүүрээр гулгаж цагийг хөгжилтэй өнгөрүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна. ОУДС-ийн нийт хамт олон та бүхэн манай талбай дээр гулгахдаа дараах 2 зүйлийг сайтар анхаарна уу:

1. Шинээр байгуулсан хөл бөмбөгийн хиймэл зүлэгтэй талбайг хамгаалах
2. Гулгаж байгаа хүүхдүүдийн аюулгүй байдал

ХӨЛ БӨМБӨГИЙН ТАЛБАЙГ ХАМГААЛАХ ТАЛААР

Бид сургуулийн кафетериятай залгаа спортын шинэ талбай дээр сагсан бөмбөгийн талбайг хучиж мөсөн талбайгаа хийсэн. Спортын хиймэл зүлэгтэй талбай байгуулж өгсөн компаний мэргэжилтнүүд нь тэшүүрийн иртэй улаар дээгүүр нь хамаагүй яваад байхгүй бол мөсөн талбай нь хиймэл зүлэгтэй талбайд ямар нэгэн гэмтэл, эвдрэл учруулахгүй гэж бидэнд тайлбарласан. **Хэдийгээр хиймэл зүлэг цасаар хучигдсан ч гэсэн та бүхэн тэшүүртэйгээ спортын талбай дээгүүр явж болохгүй.**

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР

ОУДС-ийн аюулгүй байдлыг хангах, мөн цэвэрлэгээ, үйлчилгээнд нэмэлт хөрөнгө зарахгүйн тулд бид сургуулийн бүх хаалгыг цоожтой байлгана.

Зөвхөн сургуулийн зүүн талын хаалга л онгорхой байх бөгөөд зөвхөн коридор луу орно. Сургуулийн барилга болон бие засах өрөө рүү оруулахгүй. Мөсөн гулгуурын талбайг ашиглаж байгаа хүмүүс зөвхөн тэшүүрээ өмсөх болон тэшүүрээ тайлахад л коридорын зайг ашиглах боломжтой.

Мөсөн талбайг хэн ашиглах вэ? Зөвхөн ОУДС-ийн хамт олон л мөсөн гулгуурын талбайд гулгаж болно. Эцэг эх, болон насанд хүрсэн асран хамгаалагч нь хамт ирээгүй тохиолдолд сурагчдыг талбайд гулгуулахгүй.

Хэдийд талбайд гулгаж болох вэ? ОУДС-ийн хамт олон амралтын өдрүүдэд өглөө 9:00-19:00 цаг хүртэл, ажлын өдрүүдэд оройн 7 цаг хүртэл талбайд гулгаж болно. Та бүхэн талбайд гулгах зөвшөөрлийн хуудсыг бөглөж сургуулийн ресепшин Халиунаад ирүүлсэнээр манай талбайд гулгах эрхтэй болно.

Дэд Захирал Түүл зөвшөөрлийн хуудсыг бөглөж гулгах хүсэлтээ ирүүлсэн эцэг эхчүүдийн нэрсийн жагсаалтыг гаргаж сургуулийн харуулд өгнө. Эцэг

THE MEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

Эхчүүд гулгахаар ирэхдээ бүртгэлийн хуудсанд нэр, ирсэн цаг, хамт гулгахаар ирсэн сурагчдын тоог тодорхой бичнэ.

Талбай руу орох талаар: Гулгахаар ирсэн хүмүүс сургуулийн хойгуур тойрч сургуулийн гараж, контейнерыг өнгөрөн мөсөн гулгуурын талбай руу орно. (Сургуулийн барилга дотуур явахгүй)

Гулгаж дуусаад явахдаа талбай болон сургуулийн ойр орчныг цэвэрлэж өөрсдийн авчирсан эд зүйлсийг марталгүй авч явах хэрэгтэй. Гарахдаа үүдэнд сургуулийн харуулд заавал бүртгүүлнэ.

Хамгаалалтын малгай: ОУДС-ийн мөсөн талбайг ашиглаж байгаа хүмүүс өөрсдөө хамгаалалтын малгайтайгаа ирнэ. Мөсөн дээр гулгах нь аюулгүй спортод тооцогддог. Гэхдээ тэшүүрийн ир хурц байдаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа учраас ямар нэгэн гэмтэл гарч болзошгүй. Мөсөн гадаргуу өөрөө хатуу учир унахдаа толгойгоо гэмтээж болзошгүй тул сайтар анхаарах хэрэгтэй. Бүх гулгагчдыг толгойны хамгаалалттай гулгахыг бид уриалж байна.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

1 сарын 31	3-р улирлын дугуйлангууд эхэлнэ
2 сарын 1	Бага Сургуулийн 1-р семестрийн дүн гарна
2 сарын 2	“Х” долоо хоногийн талаарх мэдээлэл өгөх үүлзалт (18:30)
2 сарын 8	Дунд Сургуулийн 1-р семестрийн дүн гарна
2 сарын 8-12	АСАМИС сагсны тэмцээн Хятадын Suzhou-д болно
2 сарын 14	5-р ангийн сурагчдын эцэг эхчүүдтэй үзэсгэлэнгийн талаар хийх үүлзалт
2 сарын 16	Эцэг Эх Багш нарын хурал (13:00-19:00)
2 сарын 21	Цагаан Сарын Өдөрлөг (13:40)- Сургуулийн Заланд болно
2 сарын 22-24	Цагаан Сарын амралт, Хичээл орохгүй

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Ирэх жил ажиллах багш нарыг сонгон шалгаруулах ажил амжилттай явагдаж байна. Mr. Elya бид хоёр Бангкок, Хонг Конгт болсон багш нарыг сонгон шалгаруулах арга хэмжээнд амжилттай оролцоод ирсэн. Одоо Mr. Stearns, Mrs. Туул нар Хойд Америкийн арга хэмжээнд амжилттай оролцоод ирнэ гэж би найдаж байна.

“Х” долоо хоногийн талаарх мэдээллийг бид дахин Мэдээндээ тавилаа. Хүүхдүүдтэйгээ тэдний сонирхож байгаа арга хэмжээний сонголтын талаар та бүхэн ярилцаарай. 6 сард болох энэ 7 хоногийн арга хэмжээ маш сонирхолтой сайхан үйл явдал байх болно. Бид та бүхний санал хүсэлтийг аль болох хурдан авсанаар зардал мөнгөний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг та бүхэнд цаг алдалгүй хүргэх боломжтой.

Сагсны баг тамирчид маань удахгүй АСАМИС тэмцээнд явах гэж байна. Баг тамирчдаа дэмжиж тэдний хичээл сурлага, хоол унд, сайн унтаж байгаа эсэхэд нь анхаарал тавиарай. Хичээлдээ сайн суралцах нь хамгийн чухал шүү, Манай тамирчид бас сайн суралцдаг байх ёстой.

Дугуйлангийн талаарх мэдээлэл та бүхэнд очсон байгаа. Та бүхэн дугуйлангийн сонголт хийхэд нь хүүхдүүддээ тусалсан байх аа. 1 сарын 31-с дугуйлангууд хичээллэж эхэлнэ.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

Дэд Захирлын Мэдээлэл

Эцэг Эхчүүд ээ,

Манай сурагчдын аюулгүй байдал бидний хувьд хамгийн чухал байдаг билээ. Яаралтай гэнэтийн онцгой байдлын үед бэлэн байх үүднээс бид хэд хэдэн журам боловсруулан гаргасан. Өнгөрсөн хугацаанд бид хэд хэдэн удаа гал болон ус, бусад ослын үед авах яаралтай арга хэмжээнүүдийг амжилттай туршиж үзсэнийг та бүхэн мэдэж байгаа. Эдгээр туршилтын арга хэмжээний үеэр бид сурагчдад хэрэгтэй зайлшгүй сургалтыг тэдэнд өгөөд зогсохгүй өөрсдийн ажилд үнэлгээ өгч цаашид сайжруулах ажлын туршлагыг олж авдаг юм.

Эдгээр баталсан журмуудаас бидний туршиж үзээгүй байгаа нэг журам нь Lock Down буюу заагдсан хоргодох байранд нуугдах журам юм. Энэ журмыг бид удахгүй турших гэж байгаа. Заагдсан хоргодох байранд нуугдах гэдэг нь дараах тохиолдлуудад багш сурагчдын аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ.

- Өөрийгөө удирдах чадваргүй болсон хэн нэгэн сурагч багш, сурагчдын болон өөрийн аюулгүй байдалд заналхийлэх
- Бүү болон зэвсэгтэй гадны этгээдийн халдлага
- Хэн нэгнийг барьцаалах, хулгайлах оролдлого гарах
- Цаг агаарын байдалтай холбоотой үйл явдал гэх мэт

Дээрх тохиолдлуудын аль нэг нь ОУДС дээр гарвал яах вэ? Товчхондоо Захирал болон түүнээс үүрэг хүлээсэн нэгэн заагдсан хоргодох байранд нуугдах нууц кодыг зарлана. Ингэснээр багш ажилтнууд анги танхимынхаа хаалгыг түгжиж, хөшгөө буулган харанхуйлж сурагчдыг анги дотроо чимээгүй байлгана. Байдал намжсаны дараа заагдсан хоргодох байрнаас гарч болохыг зарлаж мэдэгдэнэ.

Мэдээж хэрэг заагдсан хоргодох байранд нуугдах журамд нарийн тодорхой заалтууд байгаа.

Манай багш нар удахгүй сурагчдад заагдсан хоргодох байранд нуугдах тухай журмыг сайтар танилцуулна. Яагаад энэ арга хэмжээг туршиж үзэх ёстойг дэлгэрэнгүй тайлбарлана. Сурагчид маань энэ заагдсан хоргодох байранд нуугдах журамтай сайтар танилцаж энэ туршилтыг хийхэд сайтар бэлтгэгдсэний дараа бид тодорхой өдрийг зарлаж энэ туршилтыг хийнэ. Бид эхний хийсэн туршилтын ажиглалт дээрээ үндэслэн юуг сайжруулах талаар анхаарч хоёр дахь туршилтыг хийнэ.

Манай бага насны сурагчдын хувьд заагдсан хоргодох байранд нуугдах туршилт амаргүй байж магадгүй гэдгийг бид ойлгож байна. Энэ туршилтыг хийхэд та бүхэн бидэнд тусалж хүүхдүүдтэйгээ айх зүйлгүй тайван байх талаар сайтар ярилцаж дэмжлэг үзүүлээрэй. Бид эхний туршилтаа хийхээс өмнө та бүхэнд хангалттай хугацааны дотор мэдээлэл өгнө. Хэрвээ та бүхэнд асууж лавлах зүйл байвал мөн та бүхний санааг зовоосон асуудал байвал надтай болон Захиралтай холбоо бариарай.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Дэд Захирал Арилдийн Туул

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өнөөдөр 1-р семестр дуусч байна. 2 сарын 1-ний Лхагва гарагт бага сургуулийн сурагчид сурлагын дүнгээ гэртээ авч очно. Та бүхэн сурлагын дүнгий нь хүүхэдтэйгээ хамт үзэж ярилцаарай. Тэдний сурч мэдсэн ололт амжилтыг та нар хамтдаа тэмдэглэж хичээлийн жилийн үлдсэн хугацаанд бодит зорилго тавиарай. Та бүхэнд асууж лавлах зүйл байвал хүүхдийнхээ багштай нь уулзаарай.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй!

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

Х Долоо Хоногийн талаар

2 сарын 2-ны Пүрэв гарагт Х долоо хоногийн талаар дунд сургуулийн сурагчдын эцэг эхчүүд та бүхэнд мэдээлэл өгөх уулзалт 18:30-д болно. Бид дунд сургуулийн сурагчдын бүх эцэг эхчүүдийг энэ уулзалтанд хүрэлцэн ирж багш нартай уулзахыг урьж байна.

Дунд Сургуулийн Хөтөлбөрийн Зохицуулагч David Chilton

Activity	Outline	Students	Approximate cost
Moscow Performing Arts	Students will travel to Moscow and immerse themselves in the Moscow art scene. They will participate in a variety of activities in conjunction with the Anglo-American School of Moscow.	Grades 6-10 Maximum 16	\$2450
China CAS	Students will have the opportunity to visit and work in rural China as well as hiking the Great Wall and learning Chinese culinary skills.	Grade 11 Maximum 20	\$1500
Senior YACs Hiking Expedition	This expedition will build on the skills learnt over the course of the year and expose senior YACs to the Mongolian wilderness where they will complete a 5-day hiking journey with minimal support.	Grades 9-11 Maximum 15	\$400
Onon Canoe Expedition	An open canoe trip through the amazing Onon valley, close to the birth place of Chinggis Khaan, an area steeped in the fantastic history of Mongolia. The group will be camping each night and be expected to cook for themselves, with supervision.	Grades 6-8 Maximum 18	\$400
Arkhangai Horse Trekking	This is a 7-day, 6-night horse trek through Arkhangai's national parks where students will visit the White Lake and Khorgo Volcano. Students will camp each night and be led by professional horse wranglers.	Grades 9-11 Maximum 20	\$350
Arkhangai Environmental Study	This activity will focus on activities that fully engage and challenge students and to recognise and deepen their understanding of our Mongolia's natural and cultural resources. Students will participate in physical challenges as well as cultural experiences and environmental projects. Students will be housed in camp lodging during this week.	Grades 6-8 Maximum 30	\$440

Installation Art Workshop (Local option)	ISU will host an international artist who will conduct a week-long workshop for students who want to develop their art skills. It will culminate with students creating their own installation. This activity is non-residential.	Grades 9-11 Maximum 15	\$300
UB Discovery (Local option)	Students will take part in a variety of activities in and around Ulaanbaatar including horse-riding, archery and Mongolian cultural activities. This activity is non-residential.	Grades 6-8 Maximum 20	\$175
Service project (Local option)	A week-long service project working with a local NGO where students will learn about the needs of the UB community and engage in meaningful service work. This activity is non-residential.	Grades 9-11 Maximum 15	\$100
Rocket heater (Local option)	Want to be part of the solution to UB pollution? Students with an interest in technology and engineering will work with <i>Flourishing Futures</i> NGO to build a rocket heater stove that could reduce emissions by up to 80%. This activity is non-residential.	Grades 9-11 Maximum 12	\$100

3-р ангийн сурагчид Уран Зургийн Галерейд зочиллоо

3-р ангийн сурагчид “Бид өөрсдийгээ хэрхэн илэрхийлдэг вэ?” сэдвийн хүрээнд 1 сарын 18-нд Уран Зургийн Галерейд зочилж реалист болон абстракт зурагнуудыг сонирхож, дүрс бэлгэдлээр утгыг хэрхэн илэрхийлдэг талаар суралцлаа. Сурагчид өнгө дүрсийг ашиглан зураачид өөрсдийн сэтгэлийг хэрхэн илэрхийлдэг талаар суралцаж дараа нь абстракт зургаар тосон будаг, шугаман зураас ашиглан өөрсдийн санааг илэрхийлсэн зурагнууд зурлаа.

3-р ангийн багш Joyce Bolyard



5 дугаар ангийн сурагчдын эцэг эхийн анхааралд,

Өнгөрсөн 11 дүгээр сард үзэсгэлэнгийн хугацаанд зохиогдох ажлын талаар төлөвлөгөө гаргахаар та бүхэнтэй уулзахад маш сайхан байлаа. Харин одоо энэ төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх цаг хугацаа хаяанд ирээд байна.

2 сарын 13-ны Даваа гарагт 5-р ангийн сурагчид маань арван долоо хоногийн хугацаатай үзэсгэлэнгийн ажлаа эхлэх гэж байна. Энэ үзэсгэлэнгийн ажлын хүрээнд бага сургуулийн төгсөх ангид асуурагчид маань “нийгэмд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ бага ч гэсэн оруулж чадна” агуулгатайгаар судалгааны ажлаа хийж үр дүнг нь тооцон гаргадаг.

Бүх 5-р ангийн сурагчид, эцэг эхчүүд та бүхнийг үзэсгэлэнгийн нээлтийн ажиллагаанд хүрэлцэн ирэхийг урьж байна. Энэ үеэр үзэсгэлэнгийн зорилго, шаардлага, эцэг эх, багш, сурагчдын үүргийн талаар та бүхэнд тайлбарлаж таны асуултад хариулт өгөх болно.

2 сарын 14 ны Мягмар гарагийн 8:30-9:30 цагт ОУДС-ийн номын санд болох манай уулзалтанд та бүхнийг хүрэлцэн ирнэ гэдэгт найдаж байна.

Gary Herbison, Liz Covington, Mags Faber

Эцэг Эхчүүд ээ,

Олон Улсын Баклавриатын байгууллага өөрийн гэсэн you tube сувагтай боллоо. Манай ОУДС-ийн Face Book дээр тус байгууллагын талаар мэдээлэл авах зарим линкүүдийг тависан байгаа. Та бүхэн ОУББ-ын үйл ажиллагааны зорилго, гурван хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар зочлоорой:

PYP

<http://www.youtube.com/watch?v=FOhS6viEg4w&list=UUh0cEFxdfhGYhJBvVZ8ckEw&index=5&feature=plcp>

MYP

<http://www.youtube.com/watch?v=AwrOnNiNQ6Q&feature=relmfu>

DP

http://www.youtube.com/watch?v=nNYiKmixwo&feature=bf_prev&list=UUh0cEFxdfhGYhJBvVZ8ckEw&lf=plcp

Learner profile

<http://www.youtube.com/watch?v=cjvktq-TAQ&feature=relmfu>

Бага Сургуулийн Хөтөлбөрийн Зохицуулагч Margriet Faber

1-р ангийн сурагчид Төв Шууданд зочиллоо

Манай ангийн сурагчид үе тэнгийхэнтэйгээ захидлаар харилцдаг бөгөөд захидал захиа шуудангаар хэрхэн илгээгдэж эзэндээ хүрдэг талаар сурч мэдэхээр Төв Шууданд зочиллоо. Төв Шуудангийн шилэн хаалгаар ороход хөтөч маань биднийг инээмсэглэн тосон авч ажилтнуудтайгаа танилцууллаа. Бид ил захидал, маркны тасаг, шуудан илгээмжийн тасгуудаар орж шуудангийн хайрцагнуудыг сонирхлоо. Дараа нь бид дотогш орж захидал илгээмжүүд хэрхэн зөөвөрлөгдөж машинд ачигдаж байгааг харлаа. Дээд давхарт гарч олон тооны том хайрцагнууд өрсөн өрөөг орж сонирхлоо. Цэнхэр хормогч өмссөн шуудангийн ажилтнууд захидлуудыг очих газраар нь ялган ангилж байхыг тэнд харлаа.

Очих орных нь кодыг тависан том шуудайнд захидлуудыг ялгаж савласан байлаа. Бельги, Америк гэж хаягласан том шуудайнуудыг манай хөтөч ялгаж авлаа.

Бид эндээс гарч коридороор явж нэгэн том өрөөнд орлоо. Энэ өрөөнд манай хөтчийн тайлбарласнаар дэлхийн олон орноос Монголд хаяглаж ирүүлсэн бүх захидал, илгээмжүүдийг хадгалдаг юм байна. Урагдсан шуудангийн уутнуудыг оёдог өрөөгөөр ч бид бас шагайгаад амжлаа.

Хөтөч маань бидэнд дурсгал болгож марк, цэцгэн хээтэй жижиг дугтуйнууд өгсөн. Бидний энэ аялалыг зохион байгуулсан Ms. Сэлэнгэ болон бидэнтэй хамт явсан Mrs. Carey, Mrs. Matthews нарт баярлалаа. Биднийг хүлээн авч ажилтайгаа танилцуулсан Төв Шуудангийн хамт олонд маш их баярлалаа.

1-р ангийн багш Greca Durant



Мөсөн гулгуур ашиглах хүсэлт гаргах маягт

(Үнэ төлбөргүй хэрэглэнэ)

Энэхүү маягтыг бөглөөд ОУДСургуулийн хүлээн авахад гулгах өдрөөсөө өмнө урьдчилан өгсөн байх шаардлагатай ба нэг гэр бүл нэг л удаа энэ маягтыг бөглөж өгөхөд хангалттай.

Би-ийн эцэг, эх, асран хамгаалагч (доогуур зур)
(Нэрээ гаргацтай дармалдаж бичнэ үү)

..... ангийн сурагч

..... ангийн сурагч

..... ангийн сурагч

..... ангийн сурагч ийн хамтаар 2012 оны өвлийн улиралд

ОУДСургуулийн мөсөн гулгуур дээр гулгах хүсэлтэй байна.

Сургуулийн анги танхим, бие засах өрөөг ашиглахгүйгээр зөвхөн мөсөн гулгуурын талбайг ашиглахаа ойлгож байна.

Мөн эргэн тойронд нь байгаа спортын талбай дээр тэшүүрээр алхаж, гулгаж болохгүйг бүрэн ойлгож байна.

Би болон миний үр хүүхэд сургуулийн эд хогшил болон спортын талбайд эвдрэл гэмтэл учруулвал түүнийг засаж залруулах эсвэл шинээр засварлах төлбөрийг бүрэн хариуцна гэдгийг ойлгож байна.

ОУДС-ийн мөсөн гулгуурын талбайг би болон миний хүүхдүүд ашиглаж байх явцад аливаа гэмтэл, бэртэл авах болон гулгаж байх явцад бидний эд хогшил алга болсон тохиолдолд учирсан хохирлын нөхөн төлбөрийг бид сургуулиар гаргуулах эрхгүй гэдгээ би хүлээн зөвшөөрч байна. Энэ тохиолдолд ОУДС бидний өмнөөс хариуцлага хүлээхгүй болохыг бас ойлгож хүлээн зөвшөөрч байна.

Огноо: _____

Гарын Үсэг _____

МАЯГТЫГ БӨГЛӨН ГУЛГАХ ӨДРӨӨСӨӨ ХЭД ХОНОГИЙН ӨМНӨ ОУДС-ИЙН РЕСЕПШИНД АВЧИРЧ ӨГНӨ ҮҮ.